



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХОЁРЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот  
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 261628 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитор: Н.Нямсүрэн  
Утас: 261628 Цахим хаяг: [nyamsurenn@audit.gov.mn](mailto:nyamsurenn@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :  
Баян ташаагийн эх Аудит ХХК  
Захирал: Т.Хоролсүрэн  
Цахим хаяг: [bte.audit@yahoo.com](mailto:bte.audit@yahoo.com)

## Агуулга

---

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Завсрын аудитын үр дүн .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/397  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭХ НЯРАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВ ХОЁРЫН ЗАХИРАЛ  
А.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>585,134,125.64</b>	<b>27,154,714,479.63</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>6,978,333,694.12</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	6,978,314,983.13
3121	Төгрөг	-	18,107.99
33	<b>Авлага</b>	<b>43,068,183.95</b>	<b>15,768,795,474.00</b>
33402	Татвар, НДШ-ийн авлага	7,852,352.95	13,000,000.00
335	Бусад авлага	35,215,831.00	15,755,795,474.00
3351	Байгууллагаас авах авлага	35,215,831.00	15,755,795,474.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>542,065,941.69</b>	<b>4,407,585,311.51</b>
351	<b>Түүхий эд материал</b>	<b>171,345,521.33</b>	<b>3,409,658,481.13</b>
35130	Эм боох материал	171,345,521.33	3,409,658,481.13
354	<b>Хангамжийн материал</b>	<b>370,720,420.36</b>	<b>997,926,830.38</b>
35410	Бичиг хэргийн материал	6,218,603.00	21,999,169.47
35420	Аж ахуйн материал	226,982,854.20	243,053,897.49
35430	Сэлбэг хэрэгсэл	2,997,862.00	15,807,341.16
35440	Түлш, шатах тослох материал	600,000.00	9,112,491.00
35450	Барилгын засварын материал	250,200.00	7,922,975.39
35460	Хүнсний материал	-	13,368,393.00
35470	Бусад хангамжийн материал	133,670,901.16	686,662,562.87
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,491,588,348.00</b>	<b>17,951,454,504.28</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,491,588,348.00</b>	<b>17,951,454,504.28</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,483,075,448.00</b>	<b>17,941,527,383.34</b>
39201	Барилга, байгууламж	-	15,994,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(245,657.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	111,010,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(13,763,572.01)
39205	Машин тоног төхөөрөмж	2,183,210,060.00	17,345,881,639.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,209,550,625.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,290,765,388.00	1,737,896,588.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(142,497,327.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,100,000.00	97,402,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(599,761.86)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,512,900.00</b>	<b>9,927,120.94</b>
39301	Програм хангамж	8,512,900.00	7,144,583.76
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39303	Бусад биет бус хөрөнгө	-	2,782,537.18
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН</b>	<b>4,076,722,473.64</b>	<b>45,106,168,983.91</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,643,444.67</b>	-
413	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,643,444.67</b>	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,074,079,028.97</b>	<b>45,106,168,983.91</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,074,079,028.97</b>	<b>45,106,168,983.91</b>
512	Хуримтлагдсан үр дүн	4,074,079,028.97	4,074,079,028.97
51220	Тайлант үеийн үр дүн	4,074,079,028.97	45,106,168,983.91
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,076,722,473.64</b>	<b>45,106,168,983.91</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН	4,534,615,632.00	60,170,915,255.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,723,132,232.00	18,850,933,173.85
120	Нийтлэг татварын бус орлого	3,466,973,513.00	18,850,933,173.85
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,466,973,513.00	18,850,933,173.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	223,155,923.00
1200044	Үнэ төлбөргүй хүлээж авсан үндсэн хөрөнгө	-	15,419,533,496.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,466,973,513.00	3,208,243,754.14
13	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	256,158,719.00	-
122001	Хандив тусламж - Дотоод	95,000,000.00	-
122002	Хандив тусламж - Гадаад	161,158,719.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	811,483,400.00	41,319,982,082.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	811,483,400.00	520,602,650.00
1310001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	811,483,400.00	520,602,650.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	811,483,400.00	520,602,650.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн зах	811,483,400.00	493,555,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	27,047,250.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	40,799,379,432.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	40,799,379,432.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	460,536,603.03	19,138,825,300.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	460,536,603.03	18,772,368,454.53
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	460,523,483.03	18,251,233,657.53
210101	Цалингийн зардал	164,096,773.00	7,168,091,411.41
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,429,067.85	845,752,835.92
210304	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	197,037,235.21
210401	Бичиг хэргийн зардал	1,717,374.00	69,366,872.52
210402	Тээвэр, шатахууны зардал	945,000.00	24,515,523.00
210403	Шуудан, холбооны зардал	2,450,000.00	13,127,993.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал	3,695,000.00	45,653,535.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,560,748.51	359,705,317.21
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,075,933.00
210408	Бараа материал акталсны зардал	-	62,488,727.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,253,823.67	5,693,509,349.41
210502	Хоол, хүнс	41,901,400.00	2,065,513,749.01
210604	Урсгал засвар	51,488,046.00	269,082,425.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	2,986,250.00	74,239,010.00

210803	Даатгалын үйлчилгээний зардал	-	2,253,708.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	237,574.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,648,340.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,766,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	1,381,692,398.05
213	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>13,120.00</b>	<b>521,134,797.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	521,134,797.00
2135	Төсөв захирагчаас олгосон санхүүжилт	13,120.00	
22	Хөрөнгийн зардал		366,456,846.38
2200	Дотоод эх үүсвэрээр		366,456,846.38
222001	Тоног төхөөрөмж		366,456,846.38
3	Үйл ажиллагааны үр дүн	4,74,079,028.97	41,032,089,954.94
5	Нийт үр дүн	4,74,079,028.97	41,032,089,954.94

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	4,074,079,028.97	4,074,079,028.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Өмнөх үеийн үр дүн	-	-	4,074,079,028.97	4,074,079,028.97
Тайлант үеийн үр дүн	-	-	41,032,089,954.04	41,032,089,954.04
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	45,106,168,983.91	45,106,168,983.91

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>811,483,400.00</b>	<b>26,342,697,771.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>223,155,923.00</b>
120004	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>223,155,923.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	223,155,923.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>811,483,400.00</b>	<b>26,119,541,848.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>811,483,400.00</b>	<b>520,602,650.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн зах	811,483,400.00	490,605,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	811,483,400.00	29,997,250.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>223,155,923.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	25,598,939,198.00
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>595,412,542.00</b>	<b>18,575,882,172.88</b>
21	<b>Бараа ажил, үйлчилгээний зардал</b>	<b>595,399,422.00</b>	<b>18,030,882,475.88</b>



210101	Үндсэн цалингийн зардал	167,800,000.00	7,168,091,411.41
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,800,000.00	832,752,835.92
210304	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	197,037,235.21
210401	Бичиг хэргийн зардал	12,000,000.00	91,735,848.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	31,021,350.00
210403	Шуудан холбооны зардал	3,000,000.00	13,127,993.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал	10,000,000.00	74,679,935.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардал	85,801,880.00	287,925,569.87
210500	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,148,900.00	5,886,205,273.20
210502	Хоол хүнсний зардал	58,707,296.00	2,232,234,504.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	58,500,000.00	198,106,861.00
210601	Багаж, техник, хэрэгслийн зардал	27,019,500.00	456,910,680.00
210602	Тавилга		20,553,900.00
210603	Хөдөлмөр хамгаалалтын хэрэглэл	5,000,000.00	1,299,000.00
210604	Урсгал зардал	52,647,846.00	454,239,659.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	58,850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		2,253,708.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		237,574.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал	1,474,000.00	1,276,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1,479,267.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		19,916,830.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		947,000.00
213	<b>Урсгал шилжүүлэг</b>		<b>544,999,697.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		544,999,697.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,120.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>216,070,858.00</b>	<b>7,766,815,598.12</b>
4	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
5	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>216,070,858.00</b>	<b>788,481,904.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан	216,070,858.00	788,481,904.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(216,070,858.00)</b>	<b>(788,481,904.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>6,978,333,684.12</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,978,333,684.12

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<b>36,087,936,600.00</b>	<b>18,862,067,576.88</b>	<b>17,225,869,023.12</b>	<b>53.6</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>36,087,936,600.00</b>	<b>18,862,067,576.88</b>	<b>17,225,869,023.12</b>	<b>53.6</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>36,087,936,600.00</b>	<b>18,758,262,979.88</b>	<b>17,329,673,620.12</b>	<b>52.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	<b>8,074,423,300.00</b>	<b>7,131,883,711.41</b>	<b>942,539,588.59</b>	<b>88.3</b>
210101	Үндсэн цалин	3,621,047,100.00	3,418,331,335.05	202,715,764.95	94.4
210102	Нэмэгдэл	2,453,150,800.00	2,035,565,743.98	417,585,056.02	82.9
210103	Унаа, хоол бусад нөхөн олговор	603,795,300.00	450,391,511.38	153,403,788.62	74.5
210104	Урамшуулал	1,316,430,100.00	1,187,595,121.00	128,834,979.00	90.2
210105	Гэрээт ажлын цалин	80,000,000.00	40,000,000.00	40,000,000.00	50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<b>1,059,558,700.00</b>	<b>817,400,135.92</b>	<b>242,158,564.08</b>	<b>77.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	759,162,000.00	568,195,936.88	190,966,063.12	74.8
210202	Тэтгэмжийн даатгал	75,098,800.00	64,865,315.83	10,233,484.17	86.3
210203	ҮОМШӨ-ий даатгал	60,079,600.00	51,892,492.35	8,187,107.65	86.3
210204	Ажилгүйдлийн даатгал	15,019,900.00	11,481,697.45	3,538,206.59	76.4
210205	Эрүүл мэндийн даатгал	150,198,400.00	120,964,697.45	29,233,702.55	80.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>614,600,300.00</b>	<b>197,037,235.21</b>	<b>417,563,064.79</b>	<b>32.0</b>
210301	Гэрэл цахилгаан	200,591,200.00	77,447,301.76	123,143,898.24	38.6
210302	Түлш, халаалт	301,361,600.00	44,442,854.55	256,918,745.45	14.7
210303	Цэвэр, бохир ус	112,647,500.00	75,147,078.90	37,500,421.10	66.7
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>456,843,200.00</b>	<b>503,982,696.83</b>	<b>(46,739,496.83)</b>	<b>110.1</b>
210401	Бичиг хэрэг	45,125,500.00	91,691,848.00	(46,566,348.00)	201.8
210402	Тээвэр, шатахуун	40,566,500.00	31,021,350.00	9,545,150.00	76.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	190,391,000.00	74,679,935.00	115,711,065.00	39.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,760,000.00	13,127,993.96	7,632,006.04	101.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	160,000,200.00	293,061,569.87	(133,061,369.87)	183.1
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>7,843,988,600.00</b>	<b>8,346,303,638.21</b>	<b>(502,315,038.21)</b>	<b>106.4</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95,253,800.00	207,706,861.00	(112,453,061)	218.0
210502	Хоол хүнс	2,001,098,000.00	2,232,234,504.01	(231,136,504.01)	111.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,747,636,800.00	5,906,362,273.20	(158,725,473.20)	102.5
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,706,562,600.00</b>	<b>1,629,222,293.30</b>	<b>16,077,340,306.70</b>	<b>9.5</b>
210603	Багаж, техник, хэрэгсэл	15,363,956,500.00	663,853,303.00	14,700,103,197.00	4.4
	Тавилга	1,364,266,700.00	478,240,800.00	886,025,900.00	35.0
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	30,000,000.00	1,229,000.00	28,701,000.00	4.3
210604	Урсгал засвар	948,339,400.00	485,829,190.30	462,510,209.70	51.3
2108	<b>БГАҮ-ний хураамж</b>	<b>164,916,900.00</b>	<b>120,866,439.00</b>	<b>44,050,461.00</b>	<b>73.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,780,900.00	108,832,040.00	(71,601,140.00)	155.7
210803	Даатгалын үйлчилгээ	5,547,200.00	2,253,708.00	3,293,492.00	40.6
210804	Тээврийн хэрэгслийн татварын зардал	517,200.00	-	517,200.00	-

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,013,200.00	237,574.00	1,775,626.00	11.8
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал	60,000,000.00	8,513,850.00	51,486,150.00	7.9
210807	Газрын төлбөр	8,442,000.00	-	8,442,000.00	-
210809	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,328,000.00	-	2,328,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэж, бэлтгэх	48,288,400.00	1,479,267.00	46,809,133.00	3.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>167,043,000.00</b>	<b>11,966,830.00</b>	<b>155,076,170.00</b>	<b>7.1</b>
	Бараа Үйлчилгээний бусад зардал	76,920,000.00	11,019,830.00	65,900,170.00	14.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	90,123,000.00	947,000.00	89,176,000.00	1.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>103,804,597.00</b>	<b>(103,804,597.00)</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>103,804,597.00</b>	<b>(103,804,597.00)</b>	<b>0.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		103,804,597.00	(103,804,597.00)	0.00
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>36,087,936,600.00</b>	<b>25,822,095,121.00</b>	<b>10,265,841,479.00</b>	<b>71.5</b>
13400	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,923,500,100.00	25,598,939,198.00	8,324,560,902.00	71.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,923,500,100.00	25,598,939,198.00	8,324,560,902.00	71.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	<b>432,000,000.00</b>	<b>223,155,923.00</b>	<b>208,844,077.00</b>	<b>51.6</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	432,000,000.00	223,155,923.00	208,844,077.00	51.6
4	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,978,333.6	(6,978,333.6)	
61	Байгууллагын тоо	1	1		
62	Ажиллагсдын тоо	724	363		
62001	Удирдах ажилтан	18	13		
62002	Гүйцэтгэх ажилтан	706	350		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 10-ны хооронд Баян ташаагийн эх Аудит ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн, аудиторын туслах Д.Балжирдорж нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Ч.Чимгээ хэрэгжүүлсэн.

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 34 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр нь эх барих, эмэгтэйчүүд, эх ургийн болон хүүхдийн анагаах ухааныг дэлхийн жишигт нийцүүлэн хөгжүүлж, эх, хүүхэд, эмэгтэйчүүдэд нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үндэсний түвшинд үзүүлэх лавлагаа төв болон бэхжих, эх, хүүхэд, эмэгтэйчүүдийн төрөлжсөн мэргэшлийн нотолгоонд суурилсан эрүүл мэндийн чанартай, тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, ухаалаг технологи, инновацийг дэмжин ажиллах гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

. Үүнд:

- Монгол улсын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх
- Олон улсын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх
- Судалгаа шинжилгээ, туршилтын ажил хийх
- Үндэсний хэмжээнд “Нярайн скринингийн хяналт”-ын тогтолцоог бий болгох
- Гадаад харилцаа, эмнэлзүйн практик, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтыг хослуулан бэхжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа

эсэхийг судалж үзэхэд тус байгууллага нь Эрүүл мэндийн сайдын асуудлын хүрээний байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, эмнэлгийн дотоод хяналтаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох 2021 оны батлагдсан төсвийн 36,087,936.6 мянган төгрөгөөс 1.0 хувь 360,879.3 мянган төгрөгөөр, 70 хувь болох 252,615.5 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,032,089.9 мянган төгрөгөөр буюу 11 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	6,978,333.6	6,978,333.6
Авлага	43,068.1	15,768,795.4	15,725,727.2
Бараа материал	542,065.9	4,407,585.3	3,865,519.3
Үндсэн хөрөнгө	3,491,588.3	17,951,454.5	14,459,866.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,076,722.4</b>	<b>45,106,168.9</b>	<b>41,032,089.9</b>
Богино хугацаат өр төлбөр	2,643.4	0	(2,643.4)
Засгийн газрын оролцоо/Эздийн өмч/	4,074,079.0	45,106,168.9	41,032,089.9
Хуримтлагдсан үр дүн	4,074,079.0	45,106,168.9	41,032,089.9
Хөрөнгийн дахин үнэлгээний дүн			0.00
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,076,722.4</b>	<b>45,106,168.9</b>	<b>41,032,089.9</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,978,33.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа бөгөөд Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу дансны үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй .
- Авлага дансны үлдэгдэл 15,725,727.2 мянган төгрөгөөр өссөн эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт 15,200,440.2 мянган, хүнсний материал, эм эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдээс 548,389.6 мянган, Нийгмийн даатгалын авлага 13,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хүнс эм, эмнэлгийн хэрэгслийн авлага нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр тушаал Коронавируст халдварын цар тахалын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай заасны дагуу 3 сарын нөөцийг бүрдүүлсэн .
- Бараа материалын дансанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор сургалт болон бусад үйлчилгээний зориулалттай 8,740,071.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ЭМЯ-наас үнэ төлбөргүй хуваарилсан болон хандивын орлого 3,208,243.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 8,019.9 мянган төгрөгийг зарцуулсан.
- Үндсэн хөрөнгийн данс тайлант онд худалдан авалтаар 788.5 мянган төгрөг, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 15,226.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, 16,208.0 мянган төгрөгөөр нэмэгдэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлийг үндэслэн Арьсны өвчин судлалын төвд 378.8 мянган төгрөгийн ариутгалын тоног төхөөрөмжийг шилжүүлсэн.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

ЭМЯ-наас Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, төсвийн удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлэх, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын төсвийг 2021 онд дөрвөн удаа өөрчилж баталсан байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14 -ны өдрийн А/16 дугаар тушаалаар 6,017,424.5 мянган, 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/256 дугаар тушаалаар 8,082,920.9 мянган, 2021 оны 06 сарын 25-ны өдрийн А/413 дугаар тушаалаар 17,988,963.3 мянган, 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/557 дугаар тушаалаар 36,087,936.5 мянган төгрөгөөр төсвийг тус тус баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 35,655,936.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр санхүүжүүлэхээр, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоор 432,000.0 мянган төгрөг нийт 36,087,936.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 25,598,939.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, туслах үйл ажиллагааны орлогоор 223,155.9 мянган төгрөгийн орлого, нэмэлт санхүүжилтийн дансаар 520,602.6 мянган төгрөг, нийт 26,342,697.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 19,364,364.1 мянган зарцуулж, 53.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн сан дахь 100900020435 нэмэлт санхүүжилтийн дансаар эрүүл мэндийн ажилчдын санхүүгийн дэмжлэг, цар тахлын үеийн илүү цагийн хөлс, цахим эрүүл мэнд төсөл, болон гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой сургалтын зардал гарсан.

Эрүүл мэндийн яамнаас баталсан Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 53.68 хувь байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 906,331.8 мянган, НДШ-н зардал 226,805.8 мянган, бараа үйлчилгээний зардал 15,590,434.6 мянган төгрөгийн дутуу зарцуулалтаас шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	36,087,936.6	19,865,505.6	16,723,572.2	53.7
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	36,087,936.6	19,364,364.1	16,723,572.2	53.7
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж		441,195.1	(441,195.1)	-
1.3	81606	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх		50,405.4	(50,405.4)	-
1.4	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал		9,541.0	(9,541.0)	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийг “Эрүүл мэндийн даатгалын сангаас батлагдсан төлбөрийн хэмжээгээр санхүүжүүлэх журам”-ын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сантай тусламж үйлчилгээ авах гэрээ байгуулан гүйцэтгэлээр санхүүжих хэлбэрт шилжин, ТУЗ байгуулаагүй үйл ажиллагаагаа явуулж байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын барилгыг “Томо бюлдинг” ХХК концессын гэрээний дагуу барьж, 2020 оны 7 дугаар сард улсын комисс хүлээн авч акт гаргасан ба, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Гэвч “Томо бюлдинг” ХХК актаар хүлээн авсан ч эмнэлгийн барилгыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын өмчид шилжүүлэн өгөөгүй, өөрийн санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн төлбөрийн нэхэмжлэлийг ЭМДЕГ-тай 2021 оны 12 дугаар сарын 10-наар тасалбар болгон тооцоо нийлэхэд төлбөр нэхэмжилсэн дүнгээс 126 иргэний өвчтөний түүх эмнэлзүйн тусламж үйлчилгээний зөрүүтэй байдлаас шалтгаалан 2,141,879.0 мянган төгрөгөөр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу олгогдсон байна.

Энэ нь хүнд өвчлөлийн зэрэг буурсан шалтгаанаас 1,918,969.0 мянган төгрөг, эмнэлзүйн шалтгаанаар 1-5 хоногтой бусад эмнэлэг рүү эмчлүүлэхээр шилжсэн, Улсын онцгой комиссын ор зохицуулах шийдвэрээр хэвтсэн өвчтөний регистрийн дугаар зөрсөн 222,910.0 мянган төгрөг нийт 2,141,879.0 мянган төгрөг байна.

Энэ нь тус эмнэлгийн эмч нар коронавирусын халдварын оношны зэргийг буруу тодорхойлсноос шалтгаалсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлтэй гэрээ байгуулж, гүйцэтгэлээр санхүүжиж, байгууллагын төсөв санхүүгийн зарцуулалт нь ерөнхий захирлын эрхийн хүрээнд зарцуулагдаж байгаа. 2022

оны нэгдүгээр улиралд багтааж ТУЗ байгуулж, төсөв төлөвлөгөө батлуулан холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу ажиллах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийн нэхэмжлэлийн зөрүү үүсэж дутуу олгогдсон санхүүжилтийг сар бүрээр холбогдох өвчтөний түүхтэй нэг бүрчлэн тулган баталгаажуулж, шалтгааныг бүрэн тодруулж ЭМДС-тай тооцоо нийлэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн тус эмнэлэг нь короновирусын халдварт өвчлөлийн дэгдэлт дуусаж өөрийн үндсэн чиглэлийн дагуу үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор 2021 онд худалдан авах ажиллагаа батлагдсан төлөвлөгөөний дагуу тендер зарлаж, үр дүн гарсан 9 ажлын 14,557,620.4 мянган төгрөгийн, өндөр өртөгт MRI, Ангио граф, дүрс оношилгоо, ургийн монитор, удам зүйн лабораторийн аппарат, техник тоног төхөөрөмж авах гэрээ хийгдсэн ч бараа нийлүүлэлт хийгдээгүй байна. Эдгээр гэрээний биелэлтийг 2022 онд нийцлийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд нийт 76,529,551.4 мянган төгрөгийн 896 мэдээлэл Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 880 мэдээллийг хугацаандаа, 9,172,435.8 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлтэй гэрээ байгуулж, гүйцэтгэлээр санхүүжиж, байгууллагын төсөв санхүүгийн зарцуулалт нь ерөнхий захирлын эрхийн хүрээнд зарцуулагдаж байгаа. Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.1-17.10.15-т заасан заалтуудын хэрэгжилтийг авч үзэх төсөв төлөвлөгөө батлуулан холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу ажиллах шаардлагатай байна.

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёр нь өртөг тооцож аж ахуй нэгжүүдэд хэрэглэгддэг интерактив санхүүгийн программ ашигладаг. Энэ санхүүгийн программ нь төсвийн байгууллагад ашиглагддаггүй санхүүгийн тооцоолох программаар солиулах шаардлагатай байна.

### **3.10 Завсрын аудитын үр дүн**

Завсрын аудитаар нийт 51,605.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 48,106.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 3,499.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.



Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад биелэлт нь 100 хувийн байдалтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.1-17.10.15-т заасан заалтуудын хэрэгжилтийг авч үзэх, эм, эмнэлгийн хэрэгслийг нэг өвчтөнд ноогдож байгаа байдлаар судалгаа гаргах, 2021 оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу тендер шалгаруулж үр дүн гарч худалдаж авахаар гэрээ хийсэн 14,557,620.4 мянган төгрөгийн өндөр өртөгт техник тоног төхөөрөмжийн худалдан авсан үнэ, чанар, зориулалтын дагуу ашиглагдах байдал, техникийн тодорхойлолт зэрэгт хяналт хийж ажиллах шаардлагатай байна.

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын ерөнхий захирлын 2021 оны А/138 тоот тушаалаар ажилчдын нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор 2021 оны 8 дугаар сарын 1-нээс эхлэн бүх ажилтан, албан хаагчдад хариуцлагын нэмэгдэл 100 хувь олгож, 1,006,539.9 мянган төгрөгийг зарцуулсан. Энэ онд 2022 оны 3 дугаар сарын 31 хүртэл уг нэмэгдэл олгогдохоор дахин шийдвэр гаргасан байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 65,266.6 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс завсрын аудитын явцад 16,425.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, албан шаардлага 48,840.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Албан шаардлага

4.11. Гүйцэтгэгч компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй концессын гэрээгээр барьж, ашиглалтад хүлээлгэн өгсөн барилгыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.4 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтыг мөрдөж ажиллах, албан шаардлага өгөх.

40.1.2 Тус эмнэлэг нь хамгаалах хэрэгслийн нөөцтэй байхад дахин гэрээ хийж 48,750,000.00 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 “Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно”, 8.2 “шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байгаа нь эрх үүрэг ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлж, нөөцийг холбогдох журмын дагуу бэлтгэж, төсвийг үр ашигтай зарцуулах албан шаардлага өгөх

40.1.3 Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 2021 оны 7 дугаар сарын 9-нд гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэгчид гэрээний үнэ 173,390,000.00 төгрөгийг бүрэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 “Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана”, мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.7 “Бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь” гэсэн заалтуудыг зөрчсөн нь эрх үүрэг ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгөх.

40.1.4 Тус эмнэлгийн иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын нэхэмжилсэн дүн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтээс 2,141,879,000.00 төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/40 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний түр заавар”-ын хөнгөн, хөнгөвтөр, хүнд, нэн хүнд өвчний зэргийг зөв эрэмбэлж, оношлоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн сайдын Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний түр зааврыг мөрдөж ажиллах, албан шаардлага өгөх

### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Худалдан авалттай холбоотой**

##### Илрүүлэлт:

Тайлант оны гуравдугаар улирлын байдлаар 120 аж ахуйн нэгжээс худалдан авалт хийсэн 6,230,706.1 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл, бараа материалын дүнг и-баримттай тулган шалгахад 14-н аж ахуй нэгж 45,110.7 мянган төгрөгийн борлуулалтаа НӨАТ-ын цахим системд худалдан авалтаар бүртгээгүй, цахим төлбөрийн баримтгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

##### Илрүүлэлт:

Тус байгууллагын эм зүйн албаны халдвараас хамгаалах хэрэгслийн үлдэгдлийг 2021 оны 10 дугаар сарын 19 -ний өдөр тооллого хийж тооцоо бодох явцад 3,730.8 мянган төгрөгөөр илүү байна.

##### Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн тооллого тооцооны журмын 2.3 дахь заалтыг зөрчсөн. Эд хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой ажилтан солигдох үед тооллого хийж тооцоог бодуулж сар улирлын үлдэгдлийг баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	ЭНЭҮТ-2	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Илүү олгосон цалин	Акт	1	12,049.3			1	12,049.3				
2	ЭНЭҮТ-2	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Тооцооллоор дутагдсан	Акт	1	4,376.5			1	4,376.5				
3	ЭНЭҮТ-2	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Тооллогоор илүү тоологдсон материал	Зөвлөмж	1	3,730.8							1	3,730.80
4	ЭНЭҮТ-2	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт	Зөвлөмж	1	45,110.7							1	45,110.70
5	ЭНЭҮТ-3	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Хэвтэн эмчлүүлэгчдийн төлбөрийн нэхэмжлэлийн зөрүүгээр санхүүжилт дутуу олгогдсон	Албан шаардлага	1	0.0					1	0		
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт дүн</b>					<b>5</b>	<b>65,267.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>16,425.8</b>	<b>1</b>		<b>2</b>	<b>48,841.5</b>
Нийцлийн аудитын асуудал														
1	ЭНЭҮТ-2	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл	Зөвлөмж	1	9,172,435.8							1	9,172,435.8

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	ЭНЭҮТ-2	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Тус эмнэлэг нь хамгаалах хэрэгслийн нөөцтэй байхад дахин гэрээ хийж 48,750,000.00 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.	Албан шаардлага	1	48,750.0				1	48,750.00			
3	ЭНЭҮТ-3	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 2021 оны 7 дугаар сарын 9-нд гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэгчид гэрээний үнэ 173,390,000.00 төгрөгийг бүрэн шилжүүлсэн байна.	Албан шаардлага	1	173,390.0				1	173,390.00			
4	ЭНЭҮТ-4	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	. Гүйцэтгэгч компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй концессын гэрээгээр барьж, ашиглалтад хүлээлгэн өгсөн барилгыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	Албан шаардлага	1	0.0				1	0			
5	ЭНЭҮТ-2	АХГ-2022/383/НА-СТА-ТШЗ	Тус эмнэлгийн иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын нэхэмжилсэн дүн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтээс 2,141,879,000.00 төгрөгөөр зөрүүтэй байна.	зөвлөмж	1	0.0						1	0.0	
<b>Нийцлийн аудитын асуудлын нийт дүн</b>					<b>5</b>	<b>9,394,575.8</b>	-	-	-	<b>3</b>	<b>222,140.0</b>	<b>2</b>	<b>9,172,435.8</b>	
<b>Нийт</b>					<b>10</b>	<b>9,459,843.1</b>	-	-	<b>2</b>	<b>16,425.8</b>	<b>4</b>	<b>222,140.0</b>	<b>4</b>	<b>9,221,277.3</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 50/20150054

Улаанбаатар хот

АХГ 2022/323/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өндөр насны тэтгэвэрт гарсан нэр бүхий 8 ажилтныг албан тушаалд томилон ажиллуулахдаа төрийн албан хаагчийн нэмэгдэл 12,049,300.00 (арван хоёр сая дөчин есөн мянга гурван зуун) төгрөгийг олгосон.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар 25-ны өдрийн 07 дугаар зөвлөмжийн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 12,049,300.00 (арван хоёр сая дөчин есөн мянга гурван зуун) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын захирал А.Эрдэнэтуяа, нягтлан бодогч Н.Баярхүү нарт хариуцуулав;

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Т.ХОРОЛСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-261230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-52.Docx

001090171



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 51/2022/0054  
АХГ-2022/383/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төв нь Коронавируст халдварын эмчилгээний 4,376,500.00 (дөрвөн сая гурван зуун далан зургаан мянга таван зуун) төгрөгийн 4000 ширхэг Випирон лаа илүү зарлагдаж, дутагдуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү зарлагадсан 4,376,500.00 (Дөрвөн сая гурван зуун далан зургаан мянга таван зуун) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын захирал А.Эрдэнэтуяа, нягтлан бодогч Н.Баярхүү нарт хариуцуулав;

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БАЯН ТАШЧАГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Т.ГҮНЖИДМАА  
Т.ХОРОЛСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-261230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-53.Docx

001090173



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 275/АД150054  
АХГ-2022/383/-НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь хамгаалах хэрэгслийн нөөцтэй байхад дахин гэрээ хийж, 48,750,000.00 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 "Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно", 8.2 "шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. ТБОНӨХБАУХАТХ-ийг хэрэгжүүлж, нөөцийг холбогдох журмын дагуу бэлтгэж, төсвийг үр ашигтай зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын захирал А.Эрдэнэтуяа, нягтлан бодогч Н.Баярхүү нарт даалгав;

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА

Т.ХОРОЛСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 246/A0150054

Улаанбаатар хот

АНГ-2022/383/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 2021 оны 7 дугаар сарын 9-ний өдөр гэрээ байгуулж, бэлтгэн нийлүүлэгчид гэрээний үнэ 173,390,000.00 төгрөгийг бүрэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 "Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана", мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.7 "Бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлж, нөөцийг холбогдох журмын дагуу бэлтгэж, төсвийг үр ашигтай зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын захирал А.Эрдэнэтуяа, нягтлан бодогч Н.Баярхүү нарт даалгав;

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Т.ХОРОЛСҮРЭН







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 274/АД150054  
АХГ-2022/383/НА-СГА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэгч компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй концессын гэрээгээр барьж, ашиглалтад хүлээлгэн өгсөн барилгыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.4 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ” заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох асуудлыг эрх бүхий байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, барилгыг хүлээн авч бүртгэлд тусгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын захирал А.Эрдэнэтуяа, нягтлан бодогч Н.Баярхүү нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА

Т.ХОРОЛСҮРЭН

00108C0845



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 274/A0150054  
АХГ-2022/383)-НА-СТА-ТШЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлгийн иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын нэхэмжилсэн дүн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтээс 2,141,879,000.00 төгрөгөөр зөрүүтэй байгаа нь эмчлүүлэгчийн өвчний хүндийн зэрэг буурсан, 1-5 хүртэлх хоног хэвтэн эмчлүүлэхдээ эмнэлэг хооронд шилжсэн, эмчийн онош зөрсөн, хэвтэн эмчлүүлсэн иргэний регистрийн дугаар зөрүүтэй зэргээс шалтгаалсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/40 дугаар тушаалаар баталсан "Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний түр заавар"-ын хөнгөн, хөнгөвтөр, хүнд, нэн хүнд өвчний зэргийг зөв эрэмбэлж, оношлоогүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эрүүл мэндийн сайдын Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний түр зааврыг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв хоёрын захирал А.Эрдэнэтуяа, нягтлан бодогч Н.Баярхүү нарт даалгав;

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
Т.ХОРОЛСҮРЭН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-281.Docx

0010800851





